

Armando Torres

Event commencement speech – Opening Session | Supplier Forum

Эрхэм хүндэт ханган нийлүүлэгчид, түнш байгууллагууд, хүндэт зочид та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

[Бид нээлтийн үйл ажиллагааг ийнхүү дуусгаж, хөтөлбөрийнхөө дараагийн үйл ажиллагаанд ороход бэлэн болоод байна.]

Миний өмнө үг хэлсэн эрхмүүд бидний зорилго, бидний хамтдаа туулж буй урт зам, хүрсэн ололт амжилт, мөн бидний өмнө байгаа олон боломжийн тухай ярилаа.

“Оюу толгой”-н эрхэмлэдэг, дагаж мөрддөг зарчмууд нь хамтын ирээдүйгээ бүтээлцэхэд маш чухал юм. Эдгээр зарчимд тулгуурлан бид харилцаагаа бэхжүүлж, урт хугацааны түншлэлээ бэхжүүлдэг.

“Оюу толгой” компанийн хамт олонд аль хэдийнэ дадал болсон эдгээр зарчмын тухай та бүхний олонх нь мэдэж байгаа байх.

Нэгдүгээр зарчим бол бизнесийн ёс зүй.

- Бид компанийн ажилтнууд, гэрээлэгч байгууллагууд болон хамтран ажиллагч түншүүдээ бизнесийн ёс зүйн хамгийн өндөр стандартыг баримтална гэсэн хүлээлттэй байдаг.
- Жишээлбэл, бизнесийн ёс зүйн өндөр стандартыг баримтална гэдэг нь шударга, ил тод байж, тендер, үнийн санал, ханган нийлүүлэгчдийг сонгон дүгнэх үйл явцад хөндлөнгөөс оролцохгүй, саад болохгүй байхыг хэлж буй юм.
- Бид авлига, хээл хахуулийн эсрэг хамгийн өндөр стандартыг баримталж, Монгол улсын хууль тогтоомжийг бүрэн дагаж мөрдөн ажилладаг.
- Ингэснээр бид “Оюу толгой”-н ханган нийлүүлэлтийн үйл явцыг дэлхийн жишигт байлгаж, Монголын компаниуд дэлхийн зах зээлийн тоглогч болох бат бэх суурийг бий болгож байгаа юм.

Дэлхийн зах зээлийн тоглогч болохын тулд бид өрсөлдөх чадвартай байх ёстой. Өрсөлдөх чадвартай байх нь түншүүдтэйгээ бүрэн ойлголцож, үр өгөөжтэй, цаг хугацааг баримтлан ажиллахад оршдог.

Үүний эхний алхам нь ил тод харилцаа холбоо юм. Өөрөөр хэлбэл, ханган нийлүүлэгч та бүхэн бидний хэрэгцээ шаардлага, ажлын арга барил, дотоодод хэрхэн чиглэж ажилладаг болохыг ойлгон мэдэж байх хэрэгтэй.

Түүнчлэн, зөвхөн бизнес, эсвэл компанидаа биш, Монгол Улсад хэрхэн үр өгөөжтэй ажиллаж байна вэ гэдэгтээ гол анхаарлаа хандуулан ажиллах нь чухал.

Энэ нь бүтээмж өндөр, үр ашиг ихтэй, өрсөлдөхүйц үнийг санал болгон ажиллана гэсэн үг юм.

Үр ашигтай ажиллана гэдэг нь цаг хугацаандаа ажиллах буюу аливаа ажлыг хуваарь болон төсөвт багтаан дуусгаж, үр чадварыг эрэлт хэрэгцээнд тохируулан бүтээхийг хэлнэ.

Ингэснээр бид үйл ажиллагаа явуулж байгаа газартаа урт хугацааны үр өгөөжийг бий болгох юм.

Энэ зарчмуудыг эрхэмлэн ажилласнаар бид хамтдаа ирэх олон жилүүдийн түрш дэлхийн түвшний, өрсөлдөх чадвартай үндэсний компаниудыг олон чиглэлээр бий болгоно гэдэгт итгэлтэй байна.

Өнөөдрийн арга хэмжээний үеэр яригдаж байгаа бүх зүйлс нь бид ямар компани болох, ямар зарчмуудыг баримтлан ажилладаг болох тухай юм.

“Оюу толгой” бол өрсөлдөх чадвартай, олон улсын үндэсний компани бөгөөд бид зөвхөн та бүхэнтэй, түнш байгууллагуудтайгаа хамт урдаа байгаа урт замыг түүлж, амжилтад хүрч чадна.

Бид хамтдаа Монгол Улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дэлхийн тавцанд гаргаж, үндэсний компаниудын ур чадвар, өндөр чанарын бэлгэ тэмдэг болж чадна.

Тогтвортой, хүлээн зөвшөөрөгдсөн брэнд, нэр хүндийг бий болгохын тулд бид хүндлэл, ёс зүй, хамтын зүтгэл, үүрэг хариуцлага гэсэн үнэт зүйлсээ үйлдэл болгондоо агуулан ажиллах ёстой.

Ингэснээр бид алсын хараандаа хүрч, байгалийн баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлсийг бүтээлцэж чадна.

---Ends---